МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 30

ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГ ЦАХИМ ОРЧИНД ИХ ҮЙЛДЭГДЖЭЭ



Увс аймгийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан Залилах гэмт хэргийн гаралт, гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг аймгийн хэмжээнд судлан, холбогдох арга хэмжээг авчээ.

Тус прокурорын газраас 2020, 2021 оны 2 дугаар сар хүртэлх хугацаанд бусдыг залилан мэхэлсэн нийт 16 эрүүгийн хэрэгт хяналт тавьжээ. Үүнээс 3 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, 5 хэргийг хааж шийдвэрлэсэн бол 8 хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

17.3 дугаар зүйл. Залилах

1.Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол 450.000- 14.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 240-720 ЦАГ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ, ЭСХҮЛ 6 САРААС 3 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, ЭСХҮЛ 6 САРААС 3 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ХОРИХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

www.prokuror.mn

Дээрх гэмт хэргүүдийн дийлэнх нь цахим орчинд буюу фэйсбүүк сүлжээнд үйлдэгджээ. Тухайлбал, иргэд мөнгө зээлэхийг хүссэн найзын хүсэлт, баримт бичиг хурдан шуурхай гаргаж өгнө, гадаадаас хямд үнэтэй бараа материал нийлүүлнэ, гэрээсээ ажиллаж тогтмол орлоготой болно, виз гаргаж өгнө гэсэн баталгаагүй хаягаас тавьсан заруудад итгэж 300 мянгаас 32 сая хүртэл төгрөгөөр хохирсон байна.

Судалгаагаар гэмт хэрэг үйлдэж буй хүмүүс иргэдийн гэнэн итгэмтгий, хайнга хайхрамжгүй зан, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл дутмаг байдал болон амар хялбар аргаар ашиг, орлого олох, хурдан шуурхай үйлчилгээ авах гэсэн ашиг сонирхолд нь тулгуурлан гэмт үйлдлээ хэрэгжүүлж байгаа нь тогтоогджээ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

17.3 дугаар зүйл. Залилах

2.Энэ гэмт хэргийг:
2.1.албан тушаалын байдлаа ашиглаж;
2.2.бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 10.000.000-40.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 2-8 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ХОРИХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

www.prokuror.mn

Тиймээс тус прокурорын газраас аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран цахим аргаар залилах гэмт хэргийн гаралтыг бууруулах, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас бэлтгэх, видео шторк гаргах зэрэг ажлыг хийхээр болсон байна.

Мөн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр судалгаагаар тогтоогдсон нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх асуудлаар иргэдэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулжээ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

17.3 дугаар зүйл. Залилах

3.Энэ гэмт хэргийг:
3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;
3.2.олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;
3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5-12 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ХОРИХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

/Энэ зүйлийн тайлбарыг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

www.prokuror.mn

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2872